



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

20250219 № 75

танай _____ ны № _____ т

БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЭМТ-ИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ХИШИГЖАРГАЛ
ТАНАА

Аудитын тайлан хүргүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу танай байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж, аудитын дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар нийт 1,899.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 1,899.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2 зөвлөмж өгөгдсөнийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж ажиллана уу.

Жич: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн "20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн хуулийн зохицуулалттай.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

632502082



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БҮРЭГХАНГАЙ ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2025 он

Булган аймаг дахь ТАГ-ын дарга,
тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч : Ж.Энхцоодол

Утас:70342580 Цахим хаяг: EnkhtsoodolJ@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: EnkhtsoodolJ@audit.gov.mn

Майкрофт аудит ХХК аудитор: Г.Майцэцэг

Утас: 89107138 Цахим хаяг: gombodorjmaitsetseg@gmail.com

Ахлах Аудитор: Б.Нарантуяа

Утас:99138050 Цахим хаяг: narannarka18@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, тогилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.19 № 59

танай _____ ны № _____ Т

**БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЭМТ-ИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ХИШИГЖАРГАЛ
ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Бүрэгхангай ЭМТ нь 1 хөтөлбөр 5 зориулалт арга хэмжээний хүрээнд 996,485.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 915,090.4 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Бүрэгхангай сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний А/01 тоот захирамжаар 30 хүний бүтэц орон тоотой үйл ажиллагаа явуулахаар баталж 2024 онд 25 орон тоотой үйл ажиллагаагаа явуулжээ.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 202,832.3 мянган төгрөгөөр буюу 19.6 хувиар өссөн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ДАНС	БЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	362,325,469.92	582,395,665.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	181,507,419.38	240,237,319.20
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	181,507,419.38	240,237,319.20
3121	Төгрөг	181,507,419.38	240,237,319.20
31211	Төрийн сангийн харилцах	181,507,419.38	240,237,319.20
314	Замд яваа мөнгөн хөрөнгө	0.00	0.00
33	АВЛАГА	17,148,180.00	230,955,815.17
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	230,955,815.17
333	Татаас, санхүүжилтийн авлага	17,148,180.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	163,669,870.54	111,202,531.43
351	Түүхий эд материал	110,258,507.37	60,500,085.16
3511	Тусгай зориулалттай материал	16,172,062.96	19,738,672.91
3513	Эм боох материал	94,086,444.41	40,761,412.25
354	Хангамжийн материал	51,941,363.17	49,232,446.27
3541	Бичиг хэргийн материал	659,500.00	1,041,500.00
3542	Аж ахуйн материал	42,515,085.27	43,967,885.27
3543	Сэлбэг хэрэгсэл	4,185,000.00	600,000.00
3544	Түлш, шатах тослох материал	550,000.00	715,800.00
3545	Барилгын засварын материал	0.00	127,500.00
3546	Хүнсний материал	1,754,777.90	2,622,461.00
3547	Бусад хангамжийн материал	2,277,000.00	157,300.00
356	Мал амьтад	1,470,000.00	1,470,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	469,822,333.12	452,584,490.54
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	469,822,333.12	452,584,490.54
392	Биет хөрөнгө	461,737,333.12	444,574,490.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	281,901,459.57	281,901,459.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	-59,307,604.50	-69,866,779.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,034,656.00	53,351,169.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	-52,195,759.42	-26,698,127.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	264,236,083.73	259,779,228.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-113,939,914.27	-117,449,175.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,955,305.59	74,465,005.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,602,146.83	-26,874,097.71
39209	Зам, гүүрийн байгууламж	23,677,803.20	23,677,803.20
39210	Хуримтлагдсан элэгдэл	-6,761,949.95	-8,536,395.59
39217	Ном	739,400.00	824,400.00

393	Биет бус хөрөнгө	8,085,000.00	8,010,000.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,275,000.00	-1,350,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,010,000.00	8,010,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	832,147,803.04	1,034,980,156.34
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
413	Өглөг	0.00	0.00
414	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
422	Урт хугацаат зээл	0.00	0.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	832,147,803.04	1,034,980,156.34
51	Засгийн газрын хувь оролцоо	832,147,803.04	1,034,980,156.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	208,459,592.29	208,459,592.29
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	0.00	0.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.00	0.00
51101	Өмч: - төрийн	8,010,000.00	8,010,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	427,369,665.85	618,083,310.15
5121	Өмнөх үеийн үр дүн	427,369,665.85	427,369,665.85
5122	Тайлант үеийн үр дүн		190,713,644.30
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	196,318,544.90	208,437,253.90
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	832,147,803.04	1,034,980,156.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	781,899,854.58	1,239,124,912.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,547,569.03	101,977,965.66
120	Нийтлэг татварын бус орлого	57,547,569.03	101,977,965.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,275,000.00	50,481,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,275,000.00	50,481,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	37,635,946.53	25,677,347.30
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	18,636,622.50	25,819,618.36
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	724,352,285.55	1,137,146,947.05
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	0.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70,821,600.00	70,621,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70,821,600.00	70,621,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	653,530,685.55	1,066,525,347.05
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	653,530,685.55	1,066,525,347.05
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	756,257,835.42	1,048,411,268.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	756,257,835.42	1,048,411,268.41

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	748,896,722.21	1,046,436,801.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,207,447.18	590,581,826.38
210101	Үндсэн цалин	271,560,398.73	350,272,671.67
210102	Нэмэгдэл	96,637,373.00	201,219,689.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,370,000.00	8,547,000.00
210104	Урамшуулал	36,839,875.45	30,542,465.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,778,032.75	75,828,294.58
210201	Тэтгэврийн даатгал	36,450,885.21	51,879,959.62
210202	Тэтгэмжийн даатгал	4,292,004.39	6,026,742.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,372,003.55	3,233,009.22
210204	Ажилгүйдлийн даатгал	787,035.48	2,924,760.38
210205	Эрүүл мэндийн даатгал	7,876,104.12	11,763,823.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,612,386.79	66,662,133.30
210301	Гэрэл, цахилгаан	7,476,694.79	6,652,832.58
210302	Түлш, халаалт	59,135,692.00	59,320,265.00
210303	Цэвэр, бохир ус		689,035.72
2104	Хангамж, бараа материалын зардал	24,892,970.00	37,188,959.05
210401	Бичиг хэрэг	1,884,100.00	4,484,650.00
210402	Тээвэр, шатахуун	17,089,120.00	15,780,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	869,000.00	1,266,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	469,600.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,581,150.00	5,281,560.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	114,600.00
210408	Бараа материал ақталсны зардал	0.00	10,260,799.05
2105	Нормативт зардал	97,844,163.11	147,448,243.02
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	88,115,762.51	138,994,629.12
210502	Хоол, хүнс	9,728,400.60	8,453,613.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,426,200.00	15,172,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		2,888,000.00
210604	Урсгал засвар	6,426,200.00	12,284,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,108,000.00	7,362,000.00
210702	Дотоод албан томилолт	9,108,000.00	7,362,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,363,500.00	24,088,046.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,755,100.00	22,720,426.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	419,300.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	249,300.00	206,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	180,000.00
210807	Газрын төлбөр	40,800.00	168,670.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	269,000.00	70,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,664,022.38	82,105,298.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,506,032.00	14,281,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,157,990.38	67,823,898.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,361,113.21	1,974,466.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,660,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,660,000.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	701,113.21	1,974,466.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	701,113.21	1,974,466.70
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
	Дотоод эх үүсвэрээр	0.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	25,642,019.16	190,713,644.30
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	0.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	25,642,019.16	190,713,644.30

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	708,479,105.55	973,820,311.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,275,000.00	50,481,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,275,000.00	50,481,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,275,000.00	50,481,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,275,000.00	50,481,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	707,204,105.55	923,339,311.88
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70,821,600.00	70,621,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70,821,600.00	70,621,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	636,382,505.55	852,717,711.88
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	636,382,505.55	852,717,711.88
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	697,408,619.93	902,300,412.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	697,408,619.93	902,300,412.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	690,047,506.72	900,325,945.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,207,447.18	590,581,826.38
210101	Үндсэн цалин	269,769,234.75	350,272,671.67
210102	Нэмэгдэл	98,884,943.47	201,219,689.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,346,158.73	8,547,000.00
210104	Урамшуулал	36,207,110.23	30,542,465.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,778,032.75	75,828,294.58
210201	Тэтгэврийн даатгал	36,461,238.02	51,879,959.62
210202	Тэтгэмжийн даатгал	4,289,416.21	6,026,742.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,369,933.01	3,233,009.22
210204	Ажилгүйдлийн даатгал	786,517.75	2,924,760.38

210205	Эрүүл мэндийн даатгал	7,870,927.76	11,763,823.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,612,386.79	66,662,133.30
210301	Гэрэл, цахилгаан	6,840,747.96	6,652,832.58
210302	Түлш, халаалт	59,771,638.83	59,320,265.00
210303	Цэвэр, бохир ус		689,035.72
2104	Хангамж, бараа материалын зардал	26,317,520.00	26,376,570.00
210401	Бичиг хэрэг	2,381,400.00	5,264,550.00
210402	Тээвэр, шатахуун	17,639,120.00	15,946,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	869,000.00	1,266,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	469,600.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,958,400.00	3,848,910.00
2105	Нормативт зардал	97,296,388.00	81,702,224.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	78,287,760.00	65,542,887.60
210502	Хоол, хүнс	9,113,628.00	9,321,337.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,895,000.00	6,838,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,858,200.00	13,286,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		3,283,000.00
210604	Урсгал засвар	9,858,200.00	10,003,450.00
2107	Томилолт, зочны зардал	9,108,000.00	7,362,000.00
210702	Дотоод албан томилолт	9,108,000.00	7,362,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,363,500.00	24,088,046.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,755,100.00	22,720,426.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	419,300.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	216,300.00	206,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	180,000.00
210807	Газрын төлбөр	40,800.00	168,670.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	269,000.00	70,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,506,032.00	14,438,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,506,032.00	14,438,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,361,113.21	1,974,466.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,660,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,660,000.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	701,113.21	1,974,466.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	701,113.21	1,974,466.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,070,485.62	71,519,899.82
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	60,192,350.00	12,790,000.00
	Дотоод эх үүсвэрээр	60,192,350.00	12,790,000.00
221001	Их засвар	8,000,000.00	
222001	Тоног төхөөрөмж	49,675,000.00	12,790,000.00
223001	Бусад хөрөнгө	2,517,350.00	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-60,192,350.00	-12,790,000.00
145	Бусад эх үүсвэр	0.00	0.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	0.00	0.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-49,121,864.38	58,729,899.82
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	181,507,419.38
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	240,237,319.20

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцсоны нийт дүн
	ДАНС	511+*	51,300.00	51210+51220	
С01	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	-	-
С02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
С03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
С04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
С05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
С06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
С07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	-	-
С08	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл				
Д01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	208,459,592.29	196,318,544.90	427,369,668.85	832,147,803.04
Д02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Д03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Д04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		12,118,709.00		
Д05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Д06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Д08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			190,713,644.30	190,713,644.30
Д09	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	208,459,592.29	208,437,253.90	618,083,310.15	1,034,980,156.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ДҮН	ХУВЬ
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,127,467,900.00	915,090,412.06	212,377,487.94	81.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,127,467,900.00	902,300,412.06	225,167,487.94	80.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,127,467,900.00	900,325,945.36	227,141,954.64	79.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	700,240,900.00	590,581,826.38	109,659,073.62	84.34
210101	Үндсэн цалин	386,388,100.00	350,272,671.67	36,115,428.33	90.65
210102	Нэмэгдэл	267,077,800.00	201,219,689.11	65,858,110.89	75.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,880,000.00	8,547,000.00	1,333,000.00	86.51
210104	Урамшуулал	36,895,000.00	30,542,465.60	6,352,534.40	82.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,030,100.00	75,828,294.58	11,201,805.42	87.13
210201	Тэтгэврийн даатгал	59,180,500.00	51,879,959.62	7,300,540.38	87.66
210202	Тэтгэмжийн даатгал	6,962,400.00	6,026,742.24	935,657.76	86.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,481,200.00	3,233,009.22	248,190.78	92.87
210204	Ажилгүйдлийн даатгал	3,481,200.00	2,924,760.38	556,439.62	84.02
210205	Эрүүл мэндийн даатгал	13,924,800.00	11,763,823.12	2,160,976.88	84.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,621,600.00	66,662,133.30	1,959,466.70	97.14
210301	Гэрэл, цахилгаан	8,500,000.00	6,652,832.58	1,847,167.42	78.27
210302	Түлш, халаалт	59,421,600.00	59,320,265.00	101,335.00	99.83
210303	Цэвэр, бохир ус	700,000.00	689,035.72	10,964.28	98.43
2104	Хангамж, бараа материалын зардал	59,009,600.00	26,376,570.00	32,633,030.00	44.7
210401	Бичиг хэрэг	5,601,100.00	5,264,550.00	336,550.00	93.99
210402	Тээвэр, шатахуун	40,808,400.00	15,946,310.00	24,862,090.00	39.08
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,861,200.00	1,266,800.00	594,400.00	68.06
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,738,900.00	50,000.00	4,688,900.00	1.06
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000,000.00	3,848,910.00	2,151,090.00	64.15
2105	Нормативт зардал	110,016,800.00	81,702,224.60	28,314,575.40	74.26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	83,948,100.00	65,542,887.60	18,405,212.40	78.08
210502	Хоол, хүнс	17,818,700.00	9,321,337.00	8,497,363.00	52.31
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,250,000.00	6,838,000.00	1,412,000.00	82.88
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,307,600.00	13,286,450.00	17,021,150.00	43.84
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,807,600.00	3,283,000.00	16,524,600.00	16.57
210604	Урсгал засвар	10,500,000.00	10,003,450.00	496,550.00	95.27
2107	Томилолт, зочны зардал	13,000,000.00	7,362,000.00	5,638,000.00	56.63
210702	Дотоод албан томилот	13,000,000.00	7,362,000.00	5,638,000.00	56.63
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,266,600.00	24,088,046.50	19,178,553.50	55.67

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,654,000.00	22,720,426.50	16,933,573.50	57.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00		100
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	133,950.00	166,050.00	44.65
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	206,000.00	44,000.00	82.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	33,000.00	33,000.00	50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	294,600.00	180,000.00	114,600.00	61.1
210807	Газрын төлбөр	176,000.00	168,670.00	7,330.00	95.84
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,950,000.00	70,000.00	1,880,000.00	3.59
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,974,700.00	14,438,400.00	1,536,300.00	90.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,974,700.00	14,438,400.00	1,536,300.00	90.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,974,466.70	-1,974,466.70	
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00	0.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох	0.00	1,974,466.70	-1,974,466.70	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,974,466.70	-1,974,466.70	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	12,790,000.00	-12,790,000.00	
	Дотоод эх үүсвэрээр	0.00	12,790,000.00	-12,790,000.00	
222001	Тоног төхөөрөмж	0.00	12,790,000.00	-12,790,000.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	973,820,311.88	973,820,311.88	0.00	100
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00	0.00	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	70,621,600.00	70,621,600.00	0.00	100
132001	Орон нутгийн төсвөөс	70,621,600.00	70,621,600.00	0.00	100
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС			0.00	
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	852,717,711.88	852,717,711.88	0.00	100
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	852,717,711.88	852,717,711.88	0.00	100
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	50,481,000.00	50,481,000.00	0.00	100
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,481,000.00	50,481,000.00	0.00	100
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	181,507,419.38	-181,507,419.38	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	240,237,319.20	-240,237,319.20	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	0.00
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.00	25.00	5.00	
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тайлант онд тус байгууллага нь 2024 онд 326 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 1991 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 6.1 байна.

Өнгөрсөн оны мөн үеэс эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 56 тохиолдлоор буурсан.

Эрүүл мэндийн төвийн санхүүжилттэй холбоотойгоор 2021 оноос эхлэн оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, сэргээн засах эмчилгээ зэргийг нэмэгдүүлэх зорилт тавин ажилласны үр дүнд энэ онд өдрийн эмчилгээнд 211, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээг 165, сэргээн засах тусламж үйлчилгээг 272, оношилгоо шинжилгээнд 941 хүнийг тус тус хамруулснаар хэвтэн эмчлүүлэгчдийн тоо буурах хандлагатай байна.

Эрүүл мэндийн төвийн 2024 оны батлагдсан төсөв нь 996,485.0 мянган төгрөг, 2024 оны 12-р сарын 25-ны байдлаар төсвийн гүйцэтгэлээр 852,717.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 0.5 хувиар нэмэгдүүлсэн байна.

Нэг иргэнд ноогдох санхүүжилт буюу улсын төсвөөс 620,057.7 мянган төгрөг, Үндсэн тусламж үйлчилгээ буюу гүйцэтгэлээр олсон орлого 163,001.9 мянган төгрөг, урьд оны үлдэгдэл буюу өмнөх оны үр дүн 181,507.4 мянган төгрөг, Эрүүл мэндийн сайдын А/152 тушаалаар /Эмнэлгийн үйл ажиллагааг хангах/ нэмэлт санхүүжилт 50.0 мянган төгрөг, бусад нэмэлт санхүүжилт 481.0 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээг хянаж баталгаажуулснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хянаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэгхангай ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бүрэгхангай ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 202,832.3 мянган төгрөгөөр буюу 19,6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	181,507.4	240,237.3	58,729.9
Авлага		230,955.8	-230,955.8
Бараа материал	163,669.8	111,202.5	-52,467.3
Үндсэн хөрөнгө	469,822.3	452,584.5	-20,545.6
Нийт хөрөнгө	832,147.8	1,034,980.1	202,832.3
Өр төлбөр	-	0.00	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	832,147.8	1,034,980.1	
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	832,147.8	1,034,980.1	202,832.3

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь авлагын данс байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн санал 2024 онд төлөвлөсөн дүнгээр хүртээмжтэй 58 сая төгрөг хэмнэгдэж өр үүсгэлгүй үйл ажиллагаа явуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 996,485.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 973,820.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 915,090.4 мянган төгрөг буюу хэмнэлт гарган ажилласан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			Биелэлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1	71602-Эрүүл мэндийн тусламж			0	100%
2	80302-Нэг иргэн	720,347.3	654,635.7	65,711.6	90.8%
2	81603- Үндсэн тусламж /өмнөх оны үлдэгдэл санхүүжилт/	155,516.1	198,081.9	42,565.8	127.3%

	83601-Олон улсын байгууллагаас олгосон		177.0	177.0	100%
	83602- ЗГ болон ЗД нөөц хөрөнгөөс хувиарласан		160.0	16.0	100%
3	83603-Дээд шатнаас хувиарласан	50,144.0	50,144.0	0	100%
4	80111-ОН-ын урсгал үйл ажиллагаа	70,621.6	70,621.6	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрэгхангай ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан тогилуулав.

Аудитыг “Майкрофт аудит” ХХК-ий аудитор Г.Майцэцэг, ахлах аудитор Б.Нарантуяа нар гүйцэтгэж, хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер, дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг тор орлон гүйцэтгэгч Ж.Энхцоодол нар хэрэгжүүлэв.

Бүрэгхангай ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,048,411.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,726.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 786,308 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

Аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2024 онд нийт 171 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд 166 мэдээг бүрэн мэдээлж, хугацаа хоцорсон мэдээ байхгүй, хугацаа болсоогүй 5 мэдээлэл байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шатахууны тайлан, жолоочийн замын хуудсыг стандартын дагуу хөтлөх, спидометрийн заалтыг дахин нягталж шалгаж байх, шатахууны зарцуулалтын тооцоог нягталж байх зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

Цалингийн шөнийн илүү цагийг бодохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8-т заасны дагуу шөнийн цагийн нэмэгдэл хөлс /дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж /-ийг нэмж олгох заалтыг баримталж ажиллаагүй. Бараа материалын тайлангийн үлдэгдэл санхүүгийн тайлангаас 4559795.27 зөрүүтэй байна. Энэ нь УСНБББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эмийн тооллогыг түүврийн аргаар тулган баталгаажуулахад 104 нэр төрлийн нийт 18508125.3 төгрөгийн эмийн дутуу тоологдсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг

түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, нийт эмийн зардал зөрүүтэй.

Тайлант хугацаанд орлого, зарлага, шаардах хуудсыг нягтлан бодогч, нярвын гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэж заасантай нийцэхгүй байна. Залруулсан.

Анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэх, ашиглах боломжгүй хөрөнгүүдийг актлах зэрэг бүртгэлийн ажил хийгдээгүй байгаа нь Энэ нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө" заалтыг, Засгийн газрын 2014 оны 297 дугаар "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам" -ыг 1 дүгээр хавсралт, "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ" хэрэгжүүлж ажиллаагүй байна. Залруулсан.

Завсрын аудитаар Бараа материалын дансыг санхүүгийн байдлын тайлантай тулган баталгаажуулахад төгрөгөөр дутуу тайлагнасан энэ нь УСНББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй гэсэн зөвлөмжийг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, актыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,133.0	1	1,133.0	100
Зөвлөмж	2		2		100
Нийт дүн	3	1,133.0	3	1,133.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЭМД-сангаас эрүүл мэндийн байгууллагуудад эм, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөлсийг гүйцэтгэлээр санхүүжүүлэхдээ эх олонлогийн, сиситемийн, эмч байцаагчийн гэсэн 3 төрлөөр хассан тул дотоод хяналтыг сайжруулах

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын бус зардал гаргахгүй байх, жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллогыг заавал хийж хэрэгжүүлж үлдэгдлийг баталгаажуулж хэвших, бараа материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт бичиг хүчин төгөлдөр болно", "Анхан шатны бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэж тус тус заасан байдаг. Тиймээс компанийн эрх бүхий этгээдийн гарын үсэг тамга тэмдгээр баталгаажсан анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байх

Санхүүгийн тайлан болон Анхан шатны баримтыг үдэхдээ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, НББ тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу архивлан баримтжуулж, дотоод хяналтыг сайжруулахыг санхүүгийн албанд зөвлөж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,899.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,899.1 мянган төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоож, 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн 1,899.1 мянган төгрөгийн акт тавих зөрчил илэрсэн.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага бичигдээгүй болно.

5.3 Зөвлөмж

Шатахууны тайлан, жолоочийн замын хуудсыг стандартын дагуу хөтлөх, стометрийн заалтыг дахин нягтлаж шалгаж байх, шатахууны зарцуулалтын тооцоог нягтлаж байх зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна. Зөвлөмж

Цалингийн шөнийн илүү цагийг бодохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8-т заасны дагуу шөнийн цагийн нэмэгдэл хөлс /дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж /-ийг нэмж олгох заалтыг баримтлаж ажиллаагүй байна. Зөвлөмж

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	/мянган төгрөгөөр/		Зөвлөмж
				Үүнээс		
				Залруулсан	Залруулаагүй	



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 04 дугаар сарын 10

Дугаар 44/38 - 25452520

Булган сум

ЗНА - 2025/088/ЖА - САА - ТШЗ

Толбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эмийн үлдэгдлийг түүврийн аргаар тоолоход 1,899,100 (Нэг сая найман зуун ерөн есөн мянга нэг зуун) төгрөгөөр эм дутагдсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д "Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн омч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн." гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Актаар тогтоосон 1,899,100 (Нэг сая найман зуун ерөн есөн мянга нэг зуун) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн Аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бүрэгхангай сумын ЭМТ-ийн даргын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Хишигжаргал), нягтлан бодогч (У.Загдсүрэн) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
"МАЙКРОФТ АУДИТ" ХХК-ИЙ
ЗАХИРАЛ, АУДИТОР

Ж.ХИШИГЖАРГАЛ
Г.МАЙЦЭЦЭГ

002508050